



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 136.

Зуунмод

### Шинжээч томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.5, “Шүүхийн шинжилгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь заалт, “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” -ын 2021 оны А/134 журам, Төв аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 151/ШЗ2022/02757 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 01 дүгээр хороо, 2 дугаар хороолол, 012 дугаар байрны 2 тоотод оршин суух Чингис овогт Дащдондогийн Энхжаргалын нэхэмжлэлтэй Төв аймаг, Батсүмбэр сум, Зочны тохой амралтын газарт байрлах “Зочдын өргөө” ХХК-д холбогдох иргэний хэрэгт шинжээчээр манай байгууллагыг томилсон тул шинжээчээр ажиллах албан тушаалтнаар Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Цогжавхаа)-г томилсугай.
2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүгчийн захирамжид дурьдсан асуултад дүгнэлт гаргаж, Төв аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд хургуулэх, гарсан зардлыг тооцож нэхэмжлэгч, хариуцагч талаас гаргуулахыг шинжээч Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Цогжавхаа) -д даалгасугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын удирдлагын хэлтсийн дарга (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАСАНЖАРГАЛ

41220136